## ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

**1.4.2.12. Малчдын тоог бууруулахгүй байхад чиглэсэн нийгмийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.**

“Орон нутгийн залуучуудад энтрепренершипд суурилсан Хувь хүний ур чадварыг хөгжүүлэх төсөл”-ийг Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, Аймгийн Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэн боловсруулж 20.0 сая төгрөгийн төсөвт өртөг тусгуулсан болно. Хот хөдөөгийн хувьд ялгаатай бүлгийн залуучуудын боловсролын чанарын ялгааг багасгах, малчин залуучуудыг чадавхжуулах, орон нутгийн залуучуудад энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалтыг 2 үе шаттай зохион байгуулахаар төлөвлөөд байна.

**1.4.2.13. Хөдөө аж ахуйн салбарын хүний нөөцийг чадавхжуулна. Мэргэжил сурталчлах өдөрлөг, арга хэмжээг тогтмол зохион байгуулна.**

Аймгийн Засаг даргын 2026 оны А/115 дугаар захирамжийн дагуу гадаадын 6, дотоодын 17 их, дээд сургууль, 15 байгууллагын төлөөллийг оролцуулсан “Мөрөөдлөө мэргэжил болгоё” өдөрлөгийг зохион байгуулж, ЕБС болон Политехник коллежийн 5,325 суралцагчийг хамрууллаа. Мөн 9, 12 дугаар ангийн 3,000 гаруй сурагчийг коллежийн дадлагын газартай танилцуулж, Онцгой байдал, Батлан хамгаалах, Хууль зүй, Дотоод хэргийн салбарын мэргэжил сурталчлах арга хэмжээнд 400 гаруй сурагчийг хамруулсан байна. Түүнчлэн сурагчдын мэргэжил сонголт, тандалт судалгаа, чадвар тогтоох тест, "Ажлын байртай танилцъя" аян болон "Мэргэжлээрээ бахархъя" эцэг эхийн уулзалтад 1,300 гаруй суралцагч оролцсон бөгөөд шалгалтын стресс бууруулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх хөтөлбөрт 420 гаруй сурагч хамрагдлаа. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 8,325 гаруй суралцагчид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох цогц мэдээлэл, зөвлөгөөг хүргэж ажилласан.







***Эх сурвалж:*** *Дорнод аймгийн Боловсролын газар*
*Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот*
*Хэлтсийн дарга Е.АЛТАНГЭРЭЛ*
*Емэйл: altangerel85mf@moes.edu.mn Утас: 90119007*

**2.1. Хүүхэд, гэр бүлийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлнэ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар албан даалгавар болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах олон талт арга хэмжээг зохион байгууллаа. Аймгийн Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар болон Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагатай хамтран ерөнхий боловсролын 18 сургууль, 4 цэцэрлэгийн 22 багш нарыг “Гэрээр айлчлал аргачлал”-ын сургагч багшаар бэлтгэж, чадавхжуулсан. Энэ хүрээнд “Хамтдаа – Хөгжье – Оролцъё - Хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, Гэрээр айлчлах арга хэмжээгээр дамжуулан суралцагчдын аюулгүй байдал, эрсдэлийг тандаж, хамгаалал шаардлагатай хүүхдүүдийг Хамтарсан багийн шуурхай тусламж, үйлчилгээнд холбон зуучиллаа. Хэрлэн сумын зорилтот бүлгийн 59 өрхийн 56 иргэн, дотуур байрны 18 багшид “Сэтгэл зүйн боловсрол”, “Хүмүүжлийн эерэг арга”, “Гэр бүлийн баяр хөөр” сэдэвт сургалтад хамруулан арга зүйн дэмжлэг үзүүллээ.

Боловсролын сэтгэл зүйчийн мэргэжлийн үйлчилгээг суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч болон хамт олонд хүргэх, хүүхдийн сэтгэц, танин мэдэхүй, зан үйл, харилцаа, хандлага, нийгэмшилийг дэмжих ажлыг зохион байгуулж, цэцэрлэг, сургуулийн 92 багш, 30 эцэг эх, 351 суралцагчдад сэтгэл зүйн боловсрол олгох сургалт, нөлөөллийн ажлыг цахим болон танхимаар зохион байгуулав. Мөн сэтгэл зүйн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор 8 сургуульд 120 сурагчийг хамруулсан сэтгэл зүйчийн бүлгэм байгуулж, 242 сурагчид ганцаарчилсан, 3201 сурагчид зөвлөгөө үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

Дорнод аймгийн Сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагын 6498 эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, 233 хүүхдийн гэр айлчлал хийж, Ерөнхий боловсролын 26 сургуулийн 10733  эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулан боловсролын тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, Гэр бүлийн баяр хөөр, гэр бүлийн үнэ цэнэ, аливаа болзошгүй эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх 28 төрлийн сургалт нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулснаар эцэг эх, асран хамгаалагчдын хүүхэдтэйгээ эерэг харьцах, хүүхэд хамгааллын ойлголт нэмэгдсэн.

**“ГЭРЭЭР АЙЛЧЛАЛ АРГАЧЛАЛ” СУРГАЛТ**








***Эх сурвалж:*** *Дорнод аймгийн Боловсролын газар*
*Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот*
*Хэлтсийн дарга Е.АЛТАНГЭРЭЛ*
*Емэйл: altangerel85mf@moes.edu.mn   Утас: 90119007*

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧИЙН 2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

| № | Аймаг/нийслэл | Сум/дүүрэг | Сургуулийн нэр | Сэтгэл зүйчийн овог нэр | Мэргэжлийн зэрэг /бакалавр, магистр, доктор/ | ЕБС-д хэд дэх жилдээ ажиллаж байгаа вэ? /тоо/ | Сэтгэл зүйч ахалж ажилладаг клубийн нэр | Клубийн сурагчдын тоо | Оношилгоо, судалгаанд хамрагдсан сурагчдын тоо | | | Ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдсан сурагчдын тоо /давхардсан байдлаар/ | | | Бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө, тренинг-д хамрагдсан сурагчдын тоо /давхардсан байдлаар/ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Бага бүлэг | Дунд бүлэг | Ахлах бүлэг | Бага бүлэг | Дунд бүлэг | Ахлах бүлэг | Бага бүлэг | Дунд бүлэг | Ахлах бүлэг |
| 1 | Дорнод | Хэрлэн сум | 1-р сургууль | А.Өүлэн | Бакалавр | 1 | "SEL" клуб | 16 | 232 | 160 | 432 | 2 | 8 | 4 | 54 | 85 | 79 |
| 2 | Дорнод | Хэрлэн сум | 2-р сургууль | Т.Баярмаа | Бакалавр | 1 | Sympathy | 18 | 169 | 78 | 50 | 6 | 11 | 5 | 87 | 68 | 31 |
| 3 | Дорнод | Хэрлэн сум | 5-р сургууль | Э.Өнөржаргал | Бакалавр | 2 | MINDBLOOMS | 15 | 80 | 140 | 83 | 13 | 28 | 12 | 40 | 345 | 186 |
| 4 | Дорнод | Хэрлэн сум | 8-р сургууль | Б.Золзаяа | Бакалавр | 4 | "RUOK" сэтгэл зүйн клуб | 18 | 84 | 228 | 123 | 5 | 19 | 11 | 210 | 444 | 288 |
| 5 | Дорнод | Хэрлэн сум | 11-р сургууль | Дэкреттэй байна | | | | | | | | | | | | | |
| 6 | Дорнод | Хэрлэн сум | 12-р сургууль | Э.Золжаргал | Бакалавр | 3 | "Өсвөрийн сэтгэл зүйч" | 12 | 120 | 102 | 86 | 4 | 3 | 5 | 94 | 125 | 158 |
| 7 | Дорнод | Хэрлэн сум | Хан-Уул сургууль | Э.Өлзийжаргал | Бакалавр | 2 | Psychology клуб | 16 | 310 | 220 | 120 | 25 | 32 | 23 | 85 | 145 | 110 |
| 8 | Дорнод | Баяндун сум | Баяндун ЕБС | Б.Цэрэнханд | Бакалавр | 1 | "Heart talk" клуб | 15 | 127 | 96 | 44 | 3 | 2 | 4 | 127 | 134 | 96 |
| 9 | Дорнод | Чулуунхороот сум | Чулуунхороот ЕБС | Э.Энхзул | Бакалавр | 1 | "Open mind" клуб | 10 | 166 | 121 | 77 | 4 | 3 | 4 | 50 | 100 | 60 |
| | НЭГТГЭЛ | | | | | 15 | | 120 | 1288 | 1145 | 1015 | 62 | 112 | 68 | 747 | 1446 | 1008 |

*Ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн мэдээлэл*

**2.1.2. Хүүхэд, залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ. Хүүхдийн өөрөө удирдах оролцооны байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.**

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын өөрийн удирдлагын байгууллага, хүүхэд бүрийн хөгжил, хамтын оролцоог дэмжих чиглэлээр аймгийн хэмжээний 26 сургуульд Сурагчдын зөвлөл, Өсвөрийн эмч, Үе тэнгийн сургагч багш, Эрүүл Монгол хүн, Эко клуб зэрэг суралцагчдын өөрийн удирдлагын 13 төрлийн байгууллага, клуб тогтмол үйл ажиллагаа явуулж, нийт 2,665 суралцагчийг хамруулан ажиллаж байна.

Суралцагчдын хөгжих, оролцох эрхийг хангах хүрээнд нийт 22 төрлийн арга хэмжээг санаачлан зохион байгуулж, давхардсан тоогоор 25,611 суралцагчийг хамруулсны зэрэгцээ өсвөрийн улаан загалмайн 300 сурагчийн дунд “Хүмүүнлэгийн хүчээ нэгтгэе” чуулга уулзалтыг амжилттай зохион байгууллаа.

Хүүхэд залууст эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх зорилготой уламжлалт “Цэрэг-спортын Дөл-2026” цогцолбор тэмцээнийг “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд зохион байгуулагдсан тэмцээнд аймгийн төв болон сумдын 11 сургуулийн 132 сурагч оролцож, хурд хүч, авхаалж самбаа, тэсвэр хатуужлаа сорин өрсөлдлөө.

**“ХҮМҮҮНЛЭГИЙН ХҮЧЭЭ НЭГТГЭЕ” ЧУУЛГА УУЛЗАЛТ**






***Эх сурвалж:*** *Дорнод аймгийн Боловсролын газар*
*Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот*
*Хэлтсийн дарга Е.АЛТАНГЭРЭЛ*
*Емэйл: altangerel85mf@moes.edu.mn Утас: 90119007*

Үйл ажиллагааны явцын зураг....



ДОРНОД АЙМГИЙН УЛААН ЗАГАЛМАЙН ХОРООНЫ ДАРГА

Б.ГАНБОЛД

ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРЫН ГАЗРЫН ДАРГА

Ч.АРИУНАА

ДОРНОД АЙМГИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН ГАЗРЫН ДАРГА

**ДОРНОД АЙМГИЙН ӨСВӨРИЙН УЛААН ЗАГАЛМАЙЧДЫН "ХҮМҮҮНЛЭГИЙН ХҮЧЭЭ НЭГТГЭЕ" ЧУУЛГА УУЛЗАЛТЫН УДИРДАМЖ**

2026.04.28 Чойбалсан хот

**Зорилго:**

Хүүхэд багачуудыг хүмүүнлэгийн үйлсэд уриалан оролцуулж, хүнлэг энэрэнгүй үзэл санааг төлөвшүүлэх, орон нутгийн хэмжээнд хүмүүнлэгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хүмүүнлэг хүүхэд, багачуудыг алдаршуулах, салбар хоорондын үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд оршино.

**Хамрах хүрээ:** Дорнод аймгийн өсвөрийн улаан загалмайн 300 гишүүд оролцоно.

**Ерөнхий зохион байгуулагч:** Дорнод аймгийн Улаан загалмайн хороо

**Хамтран зохион байгуулагчид:**

- Аймгийн Боловсролын газар
- Аймгийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжил хамгааллын газар
- УЗХ-ны дэргэдэх Өсвөрийн улаан загалмайн төвийн клуб
- Дорнод аймгийн Хөгжимт драмын театр

**Чуулганы оролцогчид:**

- Дорнод Аймгийн ЗДТГ-2 хүн
- Аймгийн Боловсролын газар - 2 хүн
- Аймгийн Хүүхэд Гэр бүлийн хөгжил хамгааллын газар 4 хүн
- Аймгийн Цагдаагийн газар - 1 хүн
- Сумдын АШУЗХ- 10 хүн
- Сургуулиудын дэргэдэх өсвөрийн улаан загалмай хариуцсан багш -12 хүн
- Аймгийн Хүүхдийн оролцооны байгууллага 12 хүн
- Өсвөрийн улаан загалмайн гишүүд 300 хүүхэд /Сум тус бүрээс 10 ӨУЗ гишүүн суралцагчид, аймгийн сургууль тус бүр 20 хүүхэд хамруулна.

**Хугацаа:** 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдөр

/10:00 - 14:00 цагийн хооронд/

**Хаана:** Дорнод аймгийн Хөгжимт драмын театр







## "ЦЭРЭГ-СПОРТЫН ДӨЛ-2026" ТЭМЦЭЭН







**2.2. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын орчныг сайжруулж, чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тохируулгат орчныг нэмэгдүүлнэ.**

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 32,3 сая төгрөгийн хөрөнгөөр сургалтын байгууллагын ариун цэврийн өрөөг ялгаатай хэрэгцээт суралцагчдад зориулан тохижуулахад шаардлагатай бараа материал худалдан авах тендэрт Голден стерн девелопмент ХХК шалгарч гэрээний дагуу бараа материалаа нийлүүлсэн.

***Эх сурвалж:*** *Дорнод аймгийн Боловсролын газар*
*Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот*
*Хэлтсийн дарга Е.АЛТАНГЭРЭЛ*
*Емэйл: altangerel85mf@moes.edu.mn Утас: 90119007*

Бараа материалыг аймгийн засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/191 дугаар захирамжаар байгуулагдсан комисс ажиллаж 9 нэр төрлийн 190 ширхэг бараа материалыг хүлээн авсан. Тус бараа материалыг Хэрлэн сумын ерөнхий боловсролын 2, 5, 8, 11, 12, Хан-Уул, Шинэ хөгжил сургуулиудад хуваарилан хүлээлгэн өгсөн.





**Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцүүлэн, хувилбарт сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.**

Мөшгөх судалгаагаар илэрсэн, хүнд нөхцөлд амьдарч буй болон хөгжлийн ялгаатай байдлын улмаас сургуулийн өмнөх боловсрол болон сургуульд хамрагдаж чадаагүй 43 хүүхдийн мэдээллийн санг шинээр үүсгэсэн.

Танхимын сургалтад хамрагдах боломжгүй, байнгын асаргаа шаардлагатай эдгээр хүүхдүүдийг гэр бүл, орон нутгийн онцлогт нь нийцүүлэн хувилбарт болон цахим сургалтад хамруулах зорилготой “Гэрт хүрэх багц” төслийн гүйцэтгэгчээр хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөр эрхлэгчдийн үйлдвэрчний эвлэлийн хороо шалгарч, 20.0 сая төгрөгийн гэрээ байгуулах шатны ажил хийгдэж байгаа нь боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх боломжийг бүрдүүлж хэрэгжилтийг ханган ажиллах бэлтгэл ханган ажиллаж байна.

## СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДАХ БОЛОМЖГҮЙ ХҮҮХДИЙН СУДАЛГАА

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй байгаа 1-6 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дэлгэрэнгүй судалгаа

| № | Аймаг/Нийслэл | Сум/Дүүрэг | Гэрийн хаяг | Утасны дугаар | Баг | Овог | Нэр | Нас | Хүйс | Хөгжлийн бэрхшээлийн төрөл (төрөлхийн/олдмол) | Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр | Тусгай хэрэгцээ зайлшгүй шаардлагатай бол ямар хэрэгцээ шаардлагатайг бичнэ үү. | Цэцэрлэгт хамрагдах боломжтой эсэх (Тийм/үгүй) | Хэрэв үгүй бол шалтгааныг бичнэ үү. | Боловсролын үйлчилгээнд хамруулж болох хувилбараас бичнэ үү (дэмжих төв, явуулын багш, дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг) цэнхэр өнгөөр будсан хэсгээс тохирох хэсэгт нь бөглөнө үү, өөрийн орон нутгийн нөөц боломжид тулгуурлан бичих, эдгээрээс өөр хэлбэр байгаа бол бусад гэсэн хэсэгт бичнэ үү. | Хэрэв явуулын багшийн үйл ажиллагаанд хамруулах: Тухайн хүүхдийг харьцах багш | Овог | Нэр | Хэрэв дэмжих төвийн үйлчилгээнд хамруулах: Дэмжих төвийн нэр | Дэмжих төвд тухайн хүүхэдтэй ажиллах багш | Овог | Нэр | Хэрэв дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг: Цэцэрлэгийн дугаар | Багшийн овог | Багшийн нэр | Бусад хэлбэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Дорнод | Чойбалсан | Чойбалсан сум 2 дугаар баг | 89230766 | 2 | Жадамба | Эгшиглэн | 2 | эм | Төрөлхийн | Саажилт | хэрэгцээ шаардлага байхгүй | тийм |  | 2026-2027 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамруулна. | Явуулын багшид хамруулахгүй |  |  | дэмжих төвд хамруулахгүй |  |  |  | Чойбалсан сумын цэцэрлэг | Уртнаст | Саруулчимэг |  |
| 2 | Дорнод | Чойбалсан | Чойбалсан сум 2 дугаар баг | 89294883 | 2 | Эрдэнэмөнх | Мөнхбаяр | 3 | эр | Төрөлхийн | Тулгуур эрхтэн | эцэг эх гэрээр асардаг | Үгүй | Байнгын асаргаа | Дэмжих төв | Явуулын багшид хамруулахгүй |  |  |  |  |  |  |  |  |  |  |
| 3 | Дорнод | Чойбалсан | Чойбалсан сум 2 дугаар баг | 95588578 | 2 | Дavaадорж | Урангоо | 1.4 | эм | Төрөлхийн | Даун | хэрэгцээ шаардлага байхгүй | тийм |  | 3 нас хүрхэд өдрийн цэцэрлэгт явуулна. | Явуулын багшид хамруулахгүй 3 нас хүрхээр өдрийн бүлэгт хамруулна |  |  | дэмжих төвд хамруулахгүй |  |  |  | Чойбалсан сумын цэцэрлэг | Хүдэрбаатар | Ариунаүл |  |
| 4 | Дорнод | Хэрлэн сум | 2-р баг жуков 42-1 тоот | 88861127 | 2 | Азхүү | Энхтүшиг | 2 | эр | төрөлхийн | Сонсгол | эцэг эх гэрээр асардаг | үгүй | Байнгын асаргаа | Дэмжих үйлчилгээ | Явуулын багшид хамруулахгүй 2 нас хүрхээр өдрийн бүлэгт хамруулна |  |  |  |  |  |  |  |  |  |  |
| 5 | Дорнод | Хэрлэн сум | 2-р баг Пионер 2-3 тоот | 98672492 80848927 | 2 | Эрдэнэхүү | Үйлсбадрах | 3 | эр | төрөлхийн | Ховдол хоорондын таславчийн цоорхой | эцэг эх гэрээр асардаг | үгүй | Байнгын асаргаа | Дэмжих төв | Явуулын багшид хамруулахгүй ирэх хичээлийн жил цэцэрлэгт хамруулна |  |  |  |  |  |  |  |  |  |  |
| 6 | Дорнод | 17-р цэцэрлэг | 6-р баг 94-18 тоот | 88710647 | 6 | Анхбаяр | Нандинхишиг | 2 | эм | төрөлхийн | Хоромсомын эмгэг Q-93.2 | мөлхдөг, сандал дээр суудаг | Тийм | Байнгын асаргаа | 2026-2027 оны хичээлийн жилд цэцэрлэгт хамруулна. | Б. Мөнхцэндэм | Балжинням | мөнхцэндэм |  |  |  |  | 17-р цэцэрлэг | Балжинням | Мөнхцэндэм |  |
| 7 | Дорнод | Халхгол сум | Халхгол сум 1 баг | 88451207 | 1 | Энхбаяр | Шинэбаяр | 4 | эр | төрөлхийн | Даун |  | Үгүй | Байнгын асаргаа | Дэмжих үйлчилгээ | Боломжгүй |  |  | Боломжгүй |  |  |  | Боломжгүй |  |  | Байнгын хэвтэрт байдаг памперс байнга хэрэглэдэг |
| 8 | Дорнод | Матад сум | Матад сум 3р баг | 88986944 | 3 | Баттулга | Бат-Очир | 6 | эр | төрөлхийн | Саажилт | тэрэгнцэр | Үгүй | Байнгын асаргаа | Дэмжих үйлчилгээ | Хамрагдах боломжгүй |  |  | Хөдөлгөөн засал |  |  |  | Хамрагдах боломжгүй |  |  | Байнгын хэвтэрт байдаг памперс байнга хэрэглэдэг |
| 9 | Дорнод | Матад сум | Матад сум 4р баг | 88900109 | 4 | Амгаланбат | Тэгшээ | 6 | эр | төрөлхийн | Аутизм | тэргэнцэр | Үгүй | Байнгын асаргаа | Дэмжих үйлчилгээ | Хамрагдах боломжгүй |  |  |  |  |  |  | Хамрагдах боломжгүй |  |  |  |
| 10 | Дорнод | Сэргэлэн сум | Сэргэлэн | 88086859 | 4 | Одонтуяа | Төмөрсүх | 4 | эр | төрөлхийн | Саажилт | хэвтэрт | Үгүй | Байнгын асаргаа | бүр боломжгүй. | Огт хамрагдах боломжгүй |  |  |  |  |  |  |  |  |  |  |

БОЛОВСРОЛЫН ГАЗАР

***Эх сурвалж:*** *Дорнод аймгийн Боловсролын газар*
*Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот*
*Хэлтсийн дарга Е.АЛТАНГЭРЭЛ*
*Емэйл: altangerel85mf@moes.edu.mn Утас: 90119007*

**2.2.2. Суралцагчдын мэдлэг, чадвар, авьяас, хөгжил, төлөвшлийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Хүн болох багаасаа "Гадаад хэл"-ний сургалтын төслийг үргэлжлүүлнэ.**

Аймгийн Засаг даргын 2026 оны А43 захирамжаар “Хүн болох багаасаа” гадаад хэлний сургалтын төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ онд “Хүн болох багаасаа” төсөлд 21 багц тендерт шалгаран аймгийн 23 сургуулийн 8-14 насны 2200 суралцагч орос, англи, хятад хэлний 40-60 цагийн сургалтад хамрагдсан ба сургалтыг 71 багш чиглүүлж ажилласан. Төслийн явцын талаарх мэдээллийг “Хүн болох багаасаа”, пейж хуудсаар олон нийтэд хүргэж мэдээллээр ажилласан. Төслийн Байнгын ажлын хэсгээс Захиалагчийн хяналтын дэд ажлын хэсгийн уулзалтыг 2 удаа хийсэн ба тендерт оролцогчдод мэдээлэл хүргэх, төслийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоотой хяналт тавих аргачлалын талаарх ойлголтыг нэмэгдүүлэн, дотоод хяналтыг тогтмолжуулсан.

Орос хэлний сургалтад 118 буюу 5.7 хувь, хятад хэлний сургалтад 88 буюу 4 хувь, англи хэлний сургалтад 2087 буюу 90.8 хувь, солонгос хэлний сургалтад 29 буюу 1.5 хувь нь хамрагдсан.

Аймгийн 23 сургууль, орон нутгийн “Норвуужай”, “Жигүүрт” сургалтын төвийн гадаад хэлний 71 багш төсөлд ажиллаж байна.




*Зураг 1. Төслийн тендерийн үеэр “Нэг цэгийн үйлчилгээ”, шалгарсан хуулийн этгээдийн Гэрээ байгуулж буй байдал*






*Зураг 2. Тендерт шалгарсан багцуудад ажиллах боловсон хүчний танилцуулга, байршуулсан байдал*

*https://www.facebook.com/photo/?fbid=267451230718178208&set=pcb.829057580258822*

***Эх сурвалж:*** *Дорнод аймгийн Боловсролын газар*
*Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот*
*Хэлтсийн дарга Е.АЛТАНГЭРЭЛ*
*Емэйл: altangerel85mf@moes.edu.mn  Утас: 90119007*





*Зураг 3. Англи хэлний сургалт явагдаж буй байдал*

**Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын урлаг, гоо зүйн танхимын тоног төхөөрөмж, орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.**

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 34,5 сая төгрөгийн хөрөнгөөр ерөнхий боловсролын сургуулийн урлаг, гоо зүйн танхимын тоног төхөөрөмж худалдан авах авах тендэрт Мандала Про Аудио ХХК шалгарч гэрээний дагуу тоног төхөөрөмжөө нийлүүлсэн. Тоног төхөөрөмжийг аймгийн засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/192 дугаар захирамжаар байгуулагдсан комисс ажиллаж 8 нэр төрлийн 28 ширхэг  тоног төхөөрөмжийг хүлээн авсан. Тус тоног төхөөрөмжийг Хэрлэн сумын ерөнхий боловсролын Хан–Уул сургууль, 1-р сургуулиудад хуваарилан хүлээлгэн өгсөн.







**Элсэлтийн шалгалтын эрчимжүүлсэн сургалт зохион байгуулж, амжилт үзүүлсэн багш, суралцагч, сургалтын байгууллагыг урамшуулна.**

Боловсролын газраас 2026 оны хагас жилийн байдлаар 12-р ангийн суралцагчдад зориулан 5 удаагийн онлайн сорилыг тогтмол зохион байгуулсан. “Дорнод ЭШ-2026” бүлгэмд 10 үндсэн судлагдахуунаар бичлэгээр 24, файлаар /word болон pdf/ 7 удаагийн нийт 31 удаагийн мэргэжлийн тайлбар, зөвлөмжийг бүлгэмээр дамжуулан хүргэж, суралцагчдын өөрийгөө үнэлэх боломжийг бүрдүүлж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

Багш, суралцагчид үр дүнд хамтарсан анализ хийж, шалгалтын бэлтгэлийг бодит өгөгдөлд тулгуурлан эрчимжүүлж эргэх холбоотой ажиллаж байна. Жилийн эцсээр бусад үзүүлэлтээр тайлан гарч нэгтгэнэ.

***Эх сурвалж:*** *Дорнод аймгийн Боловсролын газар*
*Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот*
*Хэлтсийн дарга Е.АЛТАНГЭРЭЛ*
*Емэйл: altangerel85mf@moes.edu.mn   Утас: 90119007*

**Байгалийн ухааны туршилтын багаж, хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх, суралцагчдын судлан шинжлэх, арга барилыг дэмжинэ.**

Дорнод аймгийн засаг даргын А/72-р захирамжаар шинжлэх ухаанч техник сэтгэлгээтэй, бүтээлч иргэнийг төлөвшүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүллээ. Үүнд: Суралцагчдын сорил туршилт, судалгаа шинжилгээ хийх чадварыг дээшлүүлэх шинжлэх ухааны туршилт бүхий оюуны бүтээлүүдийг урамшуулах, сурталчлах зорилго бүхий “Гэртээ туршья” аяныг 2026 оны 1-р сарын 01-нээс 30-ны хооронд зохион байгуулсан ба аянд Ерөнхий боловсролын 20 сургуулийн 2-11 дүгээр ангийн 1705 туршилтат контентийг 1860 хүүхэд хамтран хийж “Дорнод Эврика” фэйж хуудсанд байршуулж, 1190 хүн сэтгэгдэл үлдээж, 14597 хүн контентод хариу үйлдэл үзүүлж, 171701 хүн үзэж сонирхсон ба 2025 онтой харьцуулахад туршилтын контентын тоо 364-аар нэмэгдсэн байна. Туршилтат олимпиад: Суралцагчийн шинжлэн судлах чадварыг дэмжих зорилго бүхий тус олимпиадад 23 сургуулийн 64 багийн 200 суралцагч оролцсон ба өмнөх онтой харьцуулахад хүүхдийн тоо 30-аар нэмэгдсэн үр дүн харагдаж байна.

Дугуйлангийн суралцагчдын бүтээлийн уралдаан: Хүүхдийн авьяасыг хөгжүүлэх, хамтын ажиллагааг дэмжих зорилго бүхий бүтээлийн уралдаанд 4 /физик, хими, газарзүй, биологи/ төрлөөр 23 сургуулийн 4 судлагдахууны 55 мэргэжлийн багш оролцож, химийн хичээлийн 20, физикийн хичээлийн 11, Биологийн хичээлийн 15, газарзүйн хичээлийн 10 дугуйлангийн 600 суралцагч нийтдээ 120 гаруй бүтээл танилцуулагдсан ба өмнөх онтой харьцуулахад бүтээлийн тоо 24-ээр нэмэгдсэн байна.







*Нээлтийн үйл ажиллагаа*





***Эх сурвалж:*** *Дорнод аймгийн Боловсролын газар*
*Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот*
*Хэлтсийн дарга Е.АЛТАНГЭРЭЛ*
*Емэйл: altangerel85mf@moes.edu.mn Утас: 90119007*

*УИХ-ын гишүүн Ш.Бямбасүрэн сурагчдын бүтээлтэй танилцав*







Дугуйлангийн сурагчдын бүтээлийн хэсэг

**Улсын физикийн 37-р олимпиад зохион байгуулна**

Дорнод аймгийн Баяндун сумын харьяат, Монгол Улсын анхны онолын физикч, нэрт эрдэмтэн Дугаржавын Цэрэнгийн нэрэмжит Улсын физикийн XXXVII олимпиадыг 2026 оны 04 дүгээр сарын 04-07-ны өдрүүдэд Дорнод аймгийн Чойбалсан хотноо амжилттай зохион байгууллаа. Тус олимпиадыг Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургууль болон Монголын физикийн олимпиадын хороо хамтран зохион байгуулсан бөгөөд үйл ажиллагаанд 21 аймаг, 9 дүүргээс шалгарсан 13-74 насны нийт 152 багш, сурагч, 100 гаруй зочид, эрдэмтэн докторууд хүрэлцэн ирж оролцов. Олимпиадын орон нутгийн зохион байгуулалт, өрсөлдөөн өндөр түвшинд явагдсан бөгөөд Дорнод аймгаас оролцсон багийн гишүүдээс нэг багш, хоёр сурагч шагналт байр эзэлж, Улсын физикийн олимпиадын хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүллээ. Түүнчлэн энэ удаагийн олимпиадыг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлд онцгой анхаарч, их, дээд сургуулийн багш нарын бүтээсэн туршилтын дэвшилтэт багаж хэрэгслүүдийг ашигласан төдийгүй, тэмцээний үр дүнг бодитой тооцоход ухаалаг технологийг амжилттай нэвтрүүлэн ажиллав.

Улсын физикийн олимпиадыг орон нутагтаа өндөр түвшинд зохион байгуулахад зориулж аймгийн төсвөөс нийт 200.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн гаргасан бөгөөд тус хөрөнгө оруулалтын хүрээнд олимпиадын зохион байгуулалтын зардлыг санхүүжүүлж, орон нутгийн төрийн өмчийн 23 сургуулийн физикийн кабинетыг шинэчлэхэд зориулж 48.0 сая төгрөгийн үнэ бүхий шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг иж бүрнээр нь шийдвэрлэн хүлээлгэн өглөө.







**Эх сурвалж:** *Дорнод аймгийн Боловсролын газар*
*Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот*
*Хэлтсийн дарга Е.АЛТАНГЭРЭЛ*
*Емэйл: altangerel85mf@moes.edu.mn Утас: 90119007*






**"Сүү" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.**

Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийг дэмжих “Өдөр бүр 1 аяга сүү” арга хэмжээг 31 цэцэрлэг орон нутаг, хүүхдийн хоолны түүхий эдийн зардал болон эцэг эхийн оролцоо дэмжлэгээр нийт 119 сая төгрөгийг зарцуулан, 7 хоногийн 2-5 өдөрт хэрэгжүүлэн нийт 5817 хүүхдийг, төрийн өмчийн ерөнхий боловсролын 22 сургууль орон нутаг, хүүхдийн хоолны түүхий эдийн зардал болон эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо дэмжлэгээр нийт 174 сая төгрөгийг зарцуулан, 7 хоногийн 1-5 өдөрт хэрэгжүүлж нийт 9298 суралцагчийг хамруулан, санхүүжилтийг шийдвэрлэн, хэрэгжилтийг ханган ажилласан. Файл хавсаргав.

**2.2.3. Боловсролын байгууллагын багш, ажилтны нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Боловсролын байгууллагын багш, ажилтны хөгжлийг дэмжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.**

Аймгийн ИТХ-ын 2026 оны 03/04 дүгээр тогтоолоор багшийн хөгжлийг дэмжих 3 төсөлд 492 сая төгрөг батлагдан хэрэгжиж байна. Төслийн хүрээнд багшийн мэргэжлийн хөгжил, бүтээлч сэтгэлгээ, боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үе шаттай 19 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 20 мянга гаруй суралцагч, 3500 гаруй багш, удирдах ажилтан, эцэг эх, иргэд хамрагдсан. Цэцэрлэгийн болон бага ангийн багш нарын мэргэжлийн ур чадварыг дэмжих уралдаанд 23 багш орон сууцны урьдчилгаа болох 20.0 сая төгрөгийг авах болзлыг хангасанаар 2026 онд орон сууцны дэмжлэг авсан багшийн тоо нийт 88 болж байна.
2026 онд Тэргүүлэх мэргэшлийн зэрэгтэй багшийн тоо 74-өөр нэмэгдсэн.

"ЧАДВАРЛАГ БАГШ" АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД





***Эх сурвалж:*** *Дорнод аймгийн Боловсролын газар*
*Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот*
*Хэлтсийн дарга Е.АЛТАНГЭРЭЛ*
*Емэйл: altangerel85mf@moes.edu.mn Утас: 90119007*

2 дугаар шатанд багшийн ерөнхий чадварыг сорих 6 үзүүлэлтээр өрсөлдөж 70-аас дээш гүйцэтгэлтэй багш нар  3 дугаар шатанд оролцох эрхээ авсан.

















Дорнод 4-р цэцэрлэгийн багш С.Баярмаа



Хэрлэн сумын 9-р цэцэрлэгийн багшийн туслах Б.Энхжаргал






Цагаан-Овоо сумын-Г.Отгонз



4-р цэц-С.Баярмаа


"Цэцэрлэгийн багш" болзолт уралдаанд оролцогч 1-р цэцэрлэгийн багш Г.Мөнхбаясгалан




**2.2.4. Боловсролын байгууллагын хоол үйлдвэрлэлийн материаллаг орчныг сайжруулна. Сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлийн орчин нөхцөлийн сайжруулна.**

Аймгийн боловсролын байгууллагуудын хоол үйлчилгээг MNS 7005:2023 стандартад нийцүүлэх цогц арга хэмжээ хэрэгжиж байна. Материаллаг баазыг бэхжүүлэх хүрээнд 2026 онд Орон нутгийн хөгжлийн сангаас 147.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг 7 цэцэрлэг, 6 сургууль 2 дотуур байранд нийлүүлсэн бөгөөд одоогийн байдлаар цэцэрлэгийн 96.7 хувь, сургуулийн 86.3 хувь нь тоног төхөөрөмжөөр хангагдаад байна. Мөн "Дэээрэт" ОУБ-ын 100.8 сая төгрөгийн дэмжлэгээр Хэрлэн сумын ерөнхий боловсролын 1, 8 дугаар сургуулийн гал тогоог иж бүрэн шинэчиллээ. Түүнчлэн Ороно нутгийн хөгжлийн сангийн 50.2 сая төгрөгийн хөрөнгөөр Халхгол


***Эх сурвалж:*** *Дорнод аймгийн Боловсролын газар*
*Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот*
*Хэлтсийн дарга Е.АЛТАНГЭРЭЛ*
*Емэйл: altangerel85mf@moes.edu.mn    Утас: 90119007*

сумын Ялалт багийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд шаардлагатай 12 нэр төрлийн 15 ширхэг тоног төхөөрөмжийг худалдан авч, Аймгийн Засаг даргын А/224 дүгээр захирамжаар байгуулагдсан комисс ажиллаж хүлээн авсан байна.










**2.2.5. Боловсролын байгууллагын сургалтын болон дотуур байрны хүртээмж, орчин, нөхцөлийг сайжруулна.**

Аймгийн хэмжээнд сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилга угсралт, өргөтгөлийн нийт 11 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс Хэрлэн сумын 11 дүгээр багийн 150 ортой цэцэрлэгийн барилга 100 хувийн гүйцэтгэлтэйгээр Улсын комиссын үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад орсон. Барилга угсралтын шатанд: Цагаан-Овоо сумын 150 ортой дотуур байр (85%, гэрээ цуцлах шатанд), Баян-Уул сумын 160 ортой дотуур байр (70%), Сэргэлэн сумын 160 суудлын өргөтгөл (85%), Хэрлэн сумын 3 дугаар багийн 640 суудлын сургууль (40%), 12 дугаар сургуулийн 320 суудлын өргөтгөл (75%), "Шинэ хөгжил" сургуулийн 320 суудлын өргөтгөлийн (40%) барилгын үндсэн хийц бүтээц болон дотор заслын ажлууд тус тус хийгдэж байна. Түүнчлэн Булган сумын 80 ортой дотуур байр, Хэрлэн сумын 640 суудлын сургууль, Дашбалбар болон Матад сумын тус бүр 150 ортой цэцэрлэгийн барилгын ажил гэрээ байгуулах шатанд явагдаж байна.

Аймгийн хэмжээнд сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар, инженерийн шугам сүлжээний болон гадна орчныг шинэчлэх нийт 10 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн халаалтын шугамын засвар 100 хувийн гүйцэтгэлтэйгээр ашиглалтад орсон бөгөөд 10 дугаар цэцэрлэгийн халаалтын шугам, дулааны узелийн засварын ажил бүрэн дуусаж (100%), ашиглалтад хүлээн авах шатанд явагдаж байна. Барилга угсралтын шатанд Баянтүмэн сумын ЕБС-ийн спорт заалны барилгын ажил 75 хувийн гүйцэтгэлтэйгээр (2-р давхрын араг бүтээц,

***Эх сурвалж:*** *Дорнод аймгийн Боловсролын газар*
*Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, 304 тоот*
*Хэлтсийн дарга Е.АЛТАНГЭРЭЛ*
*Емэйл: altangerel85mf@moes.edu.mn Утас: 90119007*

